



ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН
ДАРГА Г.ӨЛЗИЙБҮРЭН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013-04-09 № 02154

Г Харьяа яамны зардлыг санхүүжүүлэхийг
зогсоох тухай

Газрын тосны газрын 2012 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар харьяа Эрдэс баялаг, эрчим хүчний болон Уул уурхайн яамны гадаад томилолт, бензин шатахуун, сэлбэг хэрэгсэл, жолоочийн цалин, шимтгэл, хэвлэл мэдээллийн зардалд нийт 107.1 сая төгрөгийг санхүүжүүлсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” 15 дугаар зүйлийн 15.4.1, 14 дүгээр зүйлийн 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ыг үндэслэн ШААРДАХ НЬ:

Харьяа яамны зардлыг санхүүжүүлэх ажиллагааг зогсоож, биелэлтийг 2013 оны 12 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Газрын тосны газрын дарга Г.Өлзийбүрэн, Эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга С.Нямдорж, ерөнхий нягтлан бодогч С.Оюун нарт хариуцуулан албан шаардлага хүргүүлэв.

АЛБАН ШААРДЛАГА ХҮРГҮҮЛСЭН:

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
АХЛАХ АУДИТОР

Ц.ГЭРЭЛ



073153